

## БАЙГАЛИЙН АЯЛАЛ - РЕКРЕАЦИЙН ГАЗРЫН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Нутаг дэвсгэрийн аялал - рекреацийн үнэлгээ хийх эхний үе шат нь байгалийн нөхцлийг судлахаас эхэлдэг байна (Л.Баясгалан, 2010). Учир нь байгалийн нөөц рекреацийн нутаг дэвсгэр ашиглалтын урьдчилсан нөхцлүүдийн нэг гол хүчин зүйл байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн төдийгүй түүний иж бүрдлийг бүхэлд нь хамардаг онцлогтой юм.

Гол зорилго нь Монгол оронд байгалийн- аялал рекреацид тохиромжтой болон тохиромжгүй бүс нутгийг үнэлэх ажлыг нэгдсэн зааварчилгаагаар хангахад оршино.

Ландшафт-рекреацийн чадавхийн үнэлгээнд дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзэж шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлно. Үүнд:

### 1. Ландшафтын үнэлгээ

1. Газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээ
2. Уур амьсгалын аялал-рекреацийн үнэлгээ
3. Гадаргын ус- рашааны аялал-рекреацийн үнэлгээ
4. Био нөөцийн аялал-рекреацийн үнэлгээ
5. Ландшафтын гоо зүйн үнэлгээ

### 2. Байгаль, түүх, соёлын дурсгалт газрын үнэлгээ

1. Байгаль-соёлын дурсгалт газар
2. Түүх- соёлын дурсгалт газар

### 3. Дэд бүтцийн үнэлгээ

1. Гатлага, зам (даваа, ус, элс, намаг, шавар, сөөгөн ширгэнэ)
2. Хот болон байнгын оршин суух газарт ойрхон эсэх
3. Төхижилтын түвшин

### 4. Газар ашиглалтын суурь нөхцөлийн үнэлгээ

1. Тариалангийн талбай
2. Одоо байгаа хот суурин газар
3. Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай
4. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн онгон болон онцгой бүс

Тухайн орон нутаг, бүс нутгийн ландшафт, байгаль, түүх, соёлын дурсгалт, дэд бүтэц, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн "Байгалийн аялал- рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээ"-г боловсруулна. Байгалийн аялал- рекреацийг

хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээг 3 шатлалтай ангиллаар нийт 4 үндсэн, 27 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.

Зураг 1. Аялал-рекреацийн чадавхийн иж бүрэн үнэлгээ хийх судалгааны аргазүйн бүдүүвч (Л.Баясгалан, 2010)



**Хүснэгт 1. Байгалийн аялал- рекреацийн тохиромжтой байдалд нөлөөлөх ландшафтын үнэлгээ**

Үндсэн хүчин зүйл	Дэд хүчин зүйл	Хэмжих нэгж	Үнэлгээ		
			Тохиромжтой (3 балл)	Хязгаарлагдмал тохиромжтой (2 балл)	Тохиромжгүй (1 балл)
<b>Газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээ</b>					
Газрын гадарга	Гадаргын налуу	Градус	12-аас доош	12-20	20-иос дээш
	Хэрчигдлийн шигүү	км <sup>2</sup> /км	0.6-аас доош	0.6-1.0	1.0-ээс дээш
<b>Уур амьсгалын аялал-рекреацийн үнэлгээ</b>					
Уур амьсгал	Агаарын дундаж температур	+10 градусаас давах хоногийн тоо	130-аас дээш	90-130	90-аас доош
	Жилд нар гийгүүлэх хугацаа	Цаг	3100-аас дээш	2700-3100	2700-аас доош
	Харьцангуй чийгшлийн дундаж утга, 13 цагт	%	50-иас дээш	40-50	40-өөс доош
	Тогтвортой цасан бүрхүүлийн үргэлжлэх хугацаа	Өдрөөр	50-иас доош	50-150	150-аас дээш
<b>Гадаргын ус, рашааны аялал-рекреацийн үнэлгээ</b>					
Гадаргын рашаан ус,	Гол, мөрний нийлбэр урсац	л/с км <sup>2</sup>	3-аас дээш	0.5-3	0.5-аас доош
	Нэгж талбайд ногдох голын нийлбэр урт	км/км <sup>2</sup>	0,20-оос дээш	0,01-0,20	0,01-ээс доош
	Хүний биед тохиромжтой байгалийн усны температур 7 дугаар сард	°C	24-өөс дээш	17-24	16-аас бага
	Гол, нуур	-	Усанд сэлэхэд тааламжтай далай, нуур, цөөрөм, голтой	Усанд сэлэхэд тохиромжтой жижиг гол,	Гол, усан сан байхгүй

				усан сантай	
	Рашааны хослол		Халуун, хүйтэн рашаан хосолсон, эмчилгээний шавар	Ямар нэг рашаантай	Байхгүй
<b>Био нөөцийн аялал-рекреацийн үнэлгээ</b>					
<b>Био нөөц</b>	Бонитетийн анги	-	I, II	III, IV	V, Va
	Ойн бүтэц, хэлбэр		Төрөл зүйлийн хувьд баялаг, ойн хэв шинжүүд дараалсан, ойн давхаргуудыг үүсгэсэн, зуун наст ой. Гайхагдам ой	Төрөл зүйлийн хувьд дунд зэрэг баялаг, ойн ургамалжилтын 2 давхарга үүсгэсэн, янз бүрийн насны моддын төлөөлөлтэй. Үзэсгэлэнт ой	Нэг хэв шинжийн ой, том модны тоо хомс, ойн ургамалжилтын 1 давхрага үүсгэсэн. Уйтгартай ой
	Модлогийн зонхилогч зүйл		Царс, нарс, сэтгэл татахуйц өвөрмөц онцлогтой	Гацуур, хус, эвэрлэг мод, шинэс, хуш	Улиас, нигүүрс
	Ойн цоорхой ба зах		Өвслөг ургамалаар баялаг үзэсгэлэнт ойн цоорхой	Ойн цоорхой ба зах	Ойн цоорхой байхгүй ба ойн захаас хол
	Ойн хомсдол	%	Ойн шигүүрэлт 10%-аас бага	Ойн шигүүрэлт 10%-60%	Ойн шигүүрэлт 60%-аас их
	Ойрхог чанар	%	5.1-10%	1.1-5.0%	1% хүртэл
	Ойн дагалдах баялаг, бүтээгдэхүүн		Самар, мөөг, жимс, жимсгэнэ элбэгтэй	Ойн дагалдах баялаг ховортой	Байхгүй
	Нэн ховор, ховор ургамлын зүйл		Элбэг	Хэвийн	Ховор
	Нэн ховор, ховор амьтны зүйл		Элбэг	Хэвийн	Ховор

<i>Ландшафтын гоо зүйн үнэлгээ</i>					
	Улсын ТХГН	-	Байгалийн цогцолборт болон дурсгалт газартай	Дурсгалт газартай	Байгалийн цогцолборт, дурсгалт газар байхгүй
	Дэлхийн өв газар	-	Дэлхийн байгалийн болон соёлын өвд бүртгэгдсэн газартай	Дэлхийн аль нэг өвд бүртгэгдсэн газартай	Өвд бүртгэгдсэн газар байхгүй
	Бохирдлын түвшин	-	Физик, хими, биологийн бохирдол илрээгүй	Бохирдлын түвшин амралтын ая тухтай байдалд нөлөөлөхөөргүй	Хэт бохирдсон, амралтанд нийцэхгүй

*Хүснэгт 2. Байгалийн аялал- рекреацийн тохиромжтой байдалд нөлөөлөх байгаль, түүх, соёлын дурсгалт газрын үнэлгээ*

Үндсэн хүчин зүйл	Дэд хүчин зүйл	Хэмжих нэгж	Үнэлгээ		
			Тохиромжтой (3 балл)	Хязгаарлагдмал тохиромжтой (2 балл)	Тохиромжгүй (1 балл)
<b>Байгаль, түүх, соёлын дурсгалт газрын үнэлгээ</b>	Байгаль-соёлын дурсгалт газрууд	-	Агуй, галт уул, хүрхрээ, нуур, хосолсон	Ямар нэг байгаль-соёлын өвтэй	Байгаль-соёлын өв дурсгал байхгүй
	Түүх-соёлын дурсгалт газрууд	-	Эртний хотын туйр, хэрэм, балгас, сүм, хийд суварга, хадны оршуулга, хадны зураг, гэрэлт хөшөө, бунхан овоо, буган хөшөө хосолсон	Ямар нэг түүх-соёлын дурсгалт газартай	Түүх-соёлын дурсгал газар байхгүй

**Хүснэгт 3. Байгалийн аялал- рекреацийн тохиромжтой байдалд нөлөөлөх дэд бүтцийн үнэлгээ**

Үндсэн хүчин зүйл	Дэд хүчин зүйл	Хэмжих нэгж	Үнэлгээ		
			Тохиромжтой (3 балл)	Хязгаарлагдмал тохиромжтой (2 балл)	Тохиромжгүй (1 балл)
Дэд бүтцийн үнэлгээ	Гатлага, зам (даваа, ус, элс, намаг, шавар, сөөгөн ширгэнэ)	-	Харьцангуй онгон байгалиараа үлдсэн урочиц бүхий зам, жимийн сүлжээтэй	Явган аяллын жим болон замын сүлжээ дунд зэрэг хөгжсөн	Замгүй, гатлахад бэрхшээлтэй намаг болон сөөгөн ширгэнэтэй
	Хот болон байнгын оршин суух газарт ойрхон эсэх	-	Яг дэргэд	1 цагийн дотор хүрэх боломжтой	Хүрэхэд 1 цагаас илүү хугацаа шаардана
	Тохижилтын түвшин	-	Тохижуулсан нутаг дэвсгэр болон байгалийн онгон урочищуудын хослолтой	Дунд зэрэг тохижуулсан	Ундны ус хомстой, огт тохижуулаагүй газар

**Хүснэгт 4. Байгалийн аялал-рекреацийн газрын тохиромжтой байдалд нөлөөлөх газар ашиглалтын суурь нөхцлийн үнэлгээ**

Ашиглалтын төрөл	Үнэлгээ баллаар	Авах арга хэмжээ
Тариалангийн талбай	0	Одоо байгаа тариалангийн талбай дээр байж болохгүй
Одоо байгаа хот, суурин газар	0	Одоо байгаа суурьшлын бүсэд байх ёсгүй
Дэд бүтэц	0	Дэд бүтэцтэй ойр боловч шороон болон авто замтай давхцахгүй байх
Улсын тусгай хамгаалалттай газар	0	Онцгой болон онгон бүсэд байж болохгүй
Уул уурхайн талбай	0	Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбайд байж болохгүй
Гол, мөрөн	0	Голтой ойр боловч хамгаалалтын бүсэд биш байх (эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг 150 м татах)
Булаг, худаг, уст цэг	0	Булаг, худаг уст цэгтэй ойр байх боловч хамгаалалтын бүсэд биш байх (эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг 150 м татах)

